



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/82/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Буян-Ундрах

Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт	12
4.3 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 95

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Д.САЙЗМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,573,870.00	5,714,263.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,212,500.00	1,462,500.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,212,500.00	1,462,500.00
31130	Нэмэлт санхүүжилт	2,212,500.00	1,462,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,361,370.00	4,251,763.00
351	Түүхий эд материал	3,305,370.00	3,595,370.00
35110	Тусгай зориулалттай материал	3,305,370.00	3,595,370.00
354	Хангамжийн материал	56,000.00	656,393.00
35410	Бичиг хэргийн материал	56,000.00	656,393.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,388,884.91	17,820,847.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,388,884.91	17,820,847.35
392	Биет хөрөнгө	20,388,884.91	17,820,847.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,000,000.00)	(5,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,844,574.00	36,980,174.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,348,019.06)	(27,885,707.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,435,736.00	21,224,490.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,543,406.03)	(12,428,109.63)
39301	Програм хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(680,000.00)	(680,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	420,000.00	420,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(420,000.00)	(420,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,962,754.91	23,535,110.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,962,754.91	23,535,110.35
51	Засгийн газрын хувь оролцоо	25,962,754.91	23,535,110.35
512	Хуримтлагдсан үр дүн	25,962,754.91	23,535,110.35
51210	Өмнөх үеийн үр дүн	25,962,754.91	25,962,754.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,427,644.56)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,962,754.91	23,535,110.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	189,908,200.00	198,425,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,661,000.00	3,055,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,661,000.00	3,055,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,661,000.00	3,055,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,661,000.00	3,055,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	182,247,200.00	195,370,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,763,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,763,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,484,200.00	195,370,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,484,200.00	195,370,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	190,598,585.69	200,853,544.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,598,585.69	200,853,544.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,422,348.20	180,741,891.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,995,995.72	139,207,696.78
210101	Үндсэн цалин	89,672,701.01	99,951,789.50
210102	Нэмэгдэл	30,873,294.71	34,840,907.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,450,000.00	4,415,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,663,739.46	19,060,364.32
210201	Тэтгэврийн даатгал	11,145,539.46	13,882,164.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,379,600.00	1,294,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,103,600.00	1,035,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,900.00	258,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,759,100.00	2,589,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,579,320.54	4,124,373.64
210301	Гэрэл, цахилгаан	721,709.14	779,969.35
210302	Түлш, халаалт	1,528,223.40	1,518,204.29
210303	Цэвэр, бохир ус	529,388.00	626,200.00
210304	Байрны түрээс	1,800,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,253,975.79	7,414,718.82
210401	Бичиг хэрэг	1,715,915.00	1,566,679.00

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	4,250,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,163,060.79	1,919,772.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	328,267.00
210408	Бараа материал акталсны зардал	1,925,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,714,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	714,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,166,600.00	1,175,700.00
210702	Дотоод албан томилолт	1,166,600.00	1,175,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,378,831.00	1,913,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,615,331.00	900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,100.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,883,885.69	6,131,037.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	631,000.00	697,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,252,885.69	5,433,537.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,176,237.49	20,111,653.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,007,000.00	1,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,007,000.00	1,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,169,237.49	18,361,653.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,169,237.49	18,361,653.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(690,385.69)	(2,427,644.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(690,385.69)	(2,427,644.56)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	26,653,140.60	26,653,140.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	26,653,140.60	26,653,140.60
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(690,385.69)	(690,385.69)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	25,962,754.91	25,962,754.91
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	25,962,754.91	25,962,754.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	25,962,754.91	25,962,754.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,427,644.56)	(2,427,644.56)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	23,535,110.35	23,535,110.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	184,145,200.00	195,370,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	184,145,200.00	195,370,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,661,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,661,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,484,200.00	195,370,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,484,200.00	195,370,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	183,376,500.00	196,120,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,376,500.00	196,120,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,302,262.51	176,008,746.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,995,995.72	139,207,696.78
210101	Үндсэн цалин	89,672,701.01	99,951,789.50
210102	Нэмэгдэл	30,873,294.71	34,840,907.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,450,000.00	4,415,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,663,739.46	19,060,364.32
210201	Тэтгэврийн даатгал	11,145,539.46	13,882,164.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,379,600.00	1,294,600.00

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,103,600.00	1,035,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,900.00	258,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,759,100.00	2,589,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,579,320.54	4,124,373.64
210301	Гэрэл, цахилгаан	721,709.14	779,969.35
210302	Түлш, халаалт	1,528,223.40	1,518,204.29
210303	Цэвэр, бохир ус	529,388.00	626,200.00
210304	Байрны түрээс	1,800,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,181,975.79	8,080,111.82
210401	Бичиг хэрэг	1,623,915.00	2,197,072.00
210402	Тээвэр, шатахуун	4,195,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,163,060.79	1,919,772.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	363,267.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,709,800.00	1,749,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	209,800.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	749,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,166,600.00	1,175,700.00
210702	Дотоод албан томилолт	1,166,600.00	1,175,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,373,831.00	1,913,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,610,331.00	900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,100.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	631,000.00	697,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	631,000.00	697,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,074,237.49	20,111,653.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,007,000.00	1,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,007,000.00	1,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,169,237.49	18,361,653.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,169,237.49	18,361,653.44
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,898,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,898,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	768,700.00	(750,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	768,700.00	(750,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,443,800.00	2,212,500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,212,500.00	1,462,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,370,400.00	177,008,746.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,370,400.00	177,008,746.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,378,200.00	176,008,746.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,663,200.00	139,207,696.78
210101	Үндсэн цалин	102,849,600.00	99,951,789.50
210102	Нэмэгдэл	33,671,100.00	34,840,907.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,142,500.00	4,415,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,631,500.00	19,060,364.32
210201	Тэтгэврийн даатгал	14,453,300.00	13,882,164.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,294,600.00	1,294,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,035,600.00	1,035,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	258,900.00	258,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,589,100.00	2,589,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,222,600.00	4,124,373.64
210301	Гэрэл, цахилгаан	786,900.00	779,969.35
210302	Түлш, халаалт	1,609,500.00	1,518,204.29
210303	Цэвэр, бохир ус	626,200.00	626,200.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,080,400.00	8,080,111.82
210401	Бичиг хэрэг	2,040,000.00	2,197,072.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,140,400.00	1,919,772.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	363,267.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,749,500.00	1,749,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	749,500.00	749,500.00

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,400,000.00	1,175,700.00
210702	Дотоод албан томилолт	1,400,000.00	1,175,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,931,000.00	1,913,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900,000.00	900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,000.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	697,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	697,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,992,200.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,992,200.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,992,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,370,400.00	195,370,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195,370,400.00	195,370,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	195,370,400.00	195,370,400.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал, Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, үр ашиг, байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, өглөг, авлагын бүртгэл зэрэг үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 198,425.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,984.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,388.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,427.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,212.5	1,462.5	(750.0)
Авлага	-	-	-
Бараа материал	3,361.4	4,251.8	890.4
Үндсэн хөрөнгө	20,388.9	17,820.8	(2,568.1)
Нийт хөрөнгө	25,962.8	23,535.1	(2,427.7)
Засгийн газрын хувь оролцоо	25,962.8	23,535.1	(2,427.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	25,962.8	23,535.1	(2,427.7)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,462.5 мянган төгрөг болж 750.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,251.8 мянган төгрөг болж 890.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,820.8 мянган төгрөг болж 2,568.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны 2,865.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан хэдий ч элэгдлийн зардал 5,433.5 мянган төгрөг тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 258,126.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 258,126.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 62,755.8 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөс 195,370.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 195,370.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 195,370.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 18,361.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 177,008.7 мянган төгрөг буюу 90.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ямар нэгэн орлого ороогүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг хугацаандаа оруулж, мэдээлсэн байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 12 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тогтоосон 269.7 мянган төгрөгийн дүнтэй 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансыг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,869.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,813.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 2,869.8 мянган төгрөгийн шагналын зардлыг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.4-т “Төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл”, Сангийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6-д “Төсвийн тухай

хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байх.

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Оны эцэст Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлангаар А буюу маш сайн дүгнэгдсэн Төрийн захиргааны албан хаагчдыг үндсэн цалингийн 40 хувиар, Төрийн үйлчилгээний албан хаагчдыг үндсэн цалингийн 25 хувиар тус тус урамшуулсан байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба	2	2,869.8	0	0	0	0	0	0	2	2,869.8
Дүн		2	2,869.8	0	0	0	0	0	0	2	2,869.8